

**“МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ийн
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ**

Үнэт цаас гаргагчийн нэр: “Монголын хөгжил үндэсний нэгдэл” ХК /НАМ/
Үнэт цаас гаргагчийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Самбуугийн гудамж, Орон зай төв 701 тоот
Холбоо барих утас: 70077999, 326126, 91918840, 99998221

Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл

Байгуулагдсан огноо: 1991-01-01
МХБ-д бүртгэгдсэн огноо: 1992-08-01
Улсын бүртгэлийн дугаар: 9010001117
Регистрийн дугаар: 2033046
Хувьцаа эзэмшигчийн тоо: 65
Үндсэн үйл ажиллагаа: Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
Гадаад худалдаа
Худалдааны зуучлал
Газар тариалан

Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчид


Үнэт цаас гаргагчийн нийт зарласан хувьцаа нь 100 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1 тэрбум ширхэг энгийн хувьцаа байх ба гаргасан хувьцаа нь 50 мянган ширхэг энгийн хувьцаа байна. Компанийн энгийн хувьцааны нэрлэсэн үнэ 100 төгрөг байна.

Компанийн зарласан хувьцаанаас эргэлтэнд гаргах шийдвэрийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл гаргана. /Компанийн дүрмийн 4.2 дахь заалт/

Одоогийн байдлаар компанийн хувьцааг дараах хувь хэмжээгээр иргэн, хуулийн этгээдүүд эзэмшиж байна.

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
1	“Монгол 999 Үндэсний нэгдэл” ХК	45,088	90.18%
2	Дотоодын аж ахуйн нэгж /2/	3	0,01%
3	Гадаад хувьцаа эзэмшигч/4иргэн ААН/	2,456	4,86%
4	Бусад хувьцаа эзэмшигчид /57 иргэн/	2,453	4,95%
	Нийт	50,000	100%

“Монголын хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц



“Монголын хөгжил үндэсний Нэгдэл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Чүлтэмийн Амарбаатар, гүйцэтгэх захирлаар Төмөрбаатарын Наранбулаг нар ажиллаж байна.

Монгол улсын хөгжлийн гарааны шинэ үед ирж байгаа бөгөөд өнөө үед компани энэ боломжийг ашиглан цар хүрээгээ өргөжүүлж, санхүүгийн болон бизнесийн шинэ төсөл боловсруулж хувьцаа эзэмшигчиддээ үр өгөөжтэй компаний сайн засаглалын кодекс хэрэгжүүлэн ажиллах үүднээс төсөл хөтөлбөрүүдэд судалгаа шинжилгээ хийх, хэргэжүүлэх боломжийн судалгаа хийсээр байна.

“Монголын хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн 2015.05.03 ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор Монгол улсын Их хурлаас 2015 оны 02-р сарын 12-ны өдрийн баталсан Чөлөөт бүсийн тухай хууль, түүнтэй холбоотой бусад хуулиуд, эрх зүйн хүрээнд “Алтанбулаг чөлөөт бүс”-ийн хөрөнгө оруулагчдын зөвлөлөлийн дэргэд Алтанбулагийн чөлөөт бүсийн менежментийг хэрэгжүүлэх чиглэлээр ”Алтанбулаг консерциум” ХХК-нд хөрөнгө оруулалт хийсэн.

Манай хөрөнгө оруулалт хийсэн “Алтанбулаг консерциум” ХХК нь Алтанбулаг, Замын –үүдийн чөлөөт бүсүүдэд бүртгүүлж, тодорхой хэмжээний газар эзэмшиж “Импортын мод, модон материалын хангамж, боловсруулах үйлдвэрлэлийн цогцолбор”, “Алтанбулаг, Замын-үүд чөлөөт бүс дамнасан цайны зам АН-3 хонгилын олон улсын авто тээвэр, ложистикийн цогцолбор”-ийн төсөл хэрэгжүүлхээр ажиллаж байна. Тус компани Монголын чөлөөт бүсүүдийг хөгжүүлэх, менежмент, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх оператор компани болох зорилго тавин ажиллаж байна.

Гэвч 2020,2021,2022 онуудад “Ковид 19” халдварт цар тахлын улмаас бүхий л салбарын түвшинд хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн ч манай компани өөрийн хэмжээнд идэвхи чармайлт гарган ажилласан жил байлаа.Монгол улсын шадар сайдын ажлын алба, МҮХАҮТанхим ,Чөлөөт бүсүүдийн хөрөнгө оруулагчдын нэгдсэн зөвлөл Алтанбулаг, Замын-үүд, Цагааннуурын чөлөөт бүсийн ЗАалбадуудтай хамтарч Төр хувийн хэвшлийн нэгдсэн Форум зохион байгууллаа. Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголтын банк, Японы Жайка төрийн бус байгууллагуудтай хамтарсан уулзалт хийж Замын-үүдийн чөлөөт бүсэд

хийх Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд “Замын-Үүд” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулан батлуулах ажилд идэвхийлэн оролцлоо.

Төр засгаас “Ковид 19” халдварт цар тахлын сорилт бэрхшээлийг даван туулж байгаа ч эдийн засгаа сэргээх урт хугацаанд олон тулгуурт дэд бүтцийг бий болгож, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжиж үүднээс Замын-үүдийн чөлөөт бүсийг яаралтай нээж чөлөөт бүсийн горимийг ашиглахаар тодорхой шийдвэр гарсан мөн Замын-Үүд Эрээний эдийн засаг хамтын ажиллагааны чөлөөт бүс байгуулахаар тохирсон олон улсын хэлэлцээрийг хоёр жил гацсан байсныг УИХ-аар 2021 оны арванхоёрдугаар сарын 23-ны өдөр соёрхон баталсан нь манай компанийн цаашдын хөгжилд түлхэц болж байна.

МХБ-ийн бүртгэлийн хураамж 2022 онын төлбөрийг төлж , МХБ-ийн сайтад холбогдох мэдээлэл өөрчлөлтийг хийж, Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цаг хугацаанд нь хуралдуулж үүргийн хангалтыг хангаж ажиллаж ирлээ.

Компанийн үйл ажиллагаа, цар хүрээг нэмэгдүүлэх хөрөнгө оруулах болон нэмж хувьцаа гаргах үүднээс Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.7.3 дахь заалт үндэслэн Монголын чөлөөт бүсүүдийг Евро азийн эдийн засгийн коридорын нэг цогц төсөл болгон хөгжүүлэх, Замын-Үүд Эрээний эдийн засаг хамтын ажиллагааны чөлөөт бүсийг хөгжүүлэх, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх менежментийн компани болох , “Алтанбулаг, Замын-үүд чөлөөт бүс дамнасан цайны зам АН-3 хонгилын олон улсын авто тээвэр, ложистикийн цогцолбор ”-ийн төсөл,Хөшигийн хөндийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын төслүүдийг дэмжиж Компанийн зарласан боловч гаргаагүй 999, 950,000 /есөн зуун ерэн есөн сая есөн зуун тавин мянган/ ширхэг, 99,995,000,000 /ерэн есөн тэрбум есөн зуун ерэн таван сая/ төгрөгийн үнэ бүхий хувьцааг эргэлтэнд оруулахаар төлөвлөн ажиллаж байна.